

## МОНГОЛЫН БҮЖГИЙН СПОРТЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

### ОРШИЛ

Монголын Бүжгийн Спортын Холбоо (МБСХ) бол Монгол улсын Бүжгийн спортын гишүүн байгууллага, орон нутгийн холбоод, хувь хүмүүс гэх мэт бүх талыг нэгтгэсэн байгууллага бөгөөд Монгол улсын Бүжгийн спортыг удирдана.

МБСХ нь 2001 онд Монгол улсад Бүжгийн спортыг зохион байгуулах, хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан. МҮОХ-ны гишүүн. ОУБСХ-ны Тэргүүлэгчдийн 2003 оны 1-р сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрээр ОУБСХ-нд элссэн. МБСХ-ны зорилго нь энэхүү ДҮРЭМ-ээр тодорхойлогдоно. МБСХ нь Монгол улсын Бүжгийн спортын бүх тэмцээнүүдийг хянаж, МБСХ-ны дүрэмд заагдсан Бүжгийн спортын тэмцээнүүдийн зөвшөөрлийг олгоно.

МБСХ-ны Гишүүн бүрийн төлөөлөл нь нийтийн спортын зарчмууд дээр үндэслэсэн Монгол улсын бүжгийн спортын бүхий л хэргийг хянах, хууль тогтоох байгууллага болох МБСХ-ны Ерөнхий чуулганд оролцох эрхтэй.

### Энэхүү ДҮРЭМ-ийн зорилго нь:

1. МБСХ-ны үйл ажиллагаа нь ил тод, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ардчилсан зарчим дээр үндэслэгдсэнийг илэрхийлэх;
2. МБСХ нь үйл ажиллагаагаа шударга ёс, ил тод байдлын зарчмаар явуулдагт баталгаа өгөх;
3. Гишүүд Ерөнхий чуулганд чөлөөтэй, үр дүнтэй оролцдогт баталгаа өгөх;
4. Тэргүүлэгчид Ерөнхий чуулганд тайлагнаж хариуцлагатай ханддагт баталгаа өгөх;
5. Монгол улсын Бүжгийн спортын өргөжилт хөгжилтийг батлах;
6. МБСХ-ны үйл ажиллагаанд бизнесийн удирдлагын орчин үеийн зарчмууд болон хууль зүйн чөлөөтэй илэрхийлэх зарчмууд хэрэглэгддэгийг батлах;
7. МБСХ-ны бодлого стратегийг тодорхойлох байгууллага болох Тэргүүлэгчид ба Ерөнхий чуулганы хоорондын ил тод, үр дүнтэй үйл ажиллагааг нотлох;
8. Удирдах хороогоор дамжин МБСХ-ны менежмент үр дүнтэй явагддагийг нотлох;
9. МБСХ-ны санхүүгийн амжилтуудыг нотлох.

### 1-р зүйл. Нэр, Хуулийн этгээд болох нь, Бүртгэгдсэн хаяг

- 1.1. Тус холбооны нэр нь “Монголын Бүжгийн Спортын Холбоо” буюу “МБСХ” болно.
- 1.2. МБСХ нь Монгол улсын Төрийн бус байгууллагын тухай хуулиар хязгаарлагдсан үүрэг хариуцлагатай бие даасан хуулийн этгээд бөгөөд Тэргүүлэгчдээс шийдвэрлэсний дагуу Монгол улс, Улаанбаатар-210648, Чингисийн өргөн чөлөө, МҮОХ-ны байр, 207 тоот өрөө гэсэн хаягаар бүртгэгдэнэ.

### 2-р зүйл. Зорилго

МБСХ нь аль нэг талыг баримтлагч бус, ашгийн бус байгууллага юм. МБСХ-ны зорилгууд нь:

- 2.1. Монгол улсад Бүжгийн спортыг сурталчлах, хөгжүүлэх, төлөөлөх, зохион байгуулах;

2.2. Гишүүн байгууллагууд болон Монгол улсын Бүжгийн спортын сонирхогчид ба мэргэжлийнхнийг хамарсан тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид, судлаачид, удирдан зохион байгуулагчид, бусад техникийн албан хаагчид болон ижил төстэй спортын хүмүүсийг нэгтгэх;

2.3. МБСХ болон түүний гишүүдийн зохион байгуулж буй бүх тэмцээнүүдийн стандартчилсан дүрмийг Бүжгийн спортын хамгийн дээд ашиг сонирхол ба спортын зарчим дээр тулгуурлан боловсруулж, хуульчлан батлах, удирдах, мөрдүүлэх;

2.4. Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын зорилгыг дэмжих;

2.5. Олимпизмийг өөрийн орон даяар сурталчлах; Монголын Үндэсний Олимпийн Хорооны зорилго эрмэлзлийг дэмжих;

2.6. Гишүүдийнхээ үйл ажиллагаа явуулахад нь зөвлөж туслах.

### **3-р зүйл. Санхүүгийн жил**

Санхүүгийн жил нь хуанлийн жилээр тодорхойлогдоно.

### **4-р зүйл. Гишүүнчлэл**

МБСХ-ны гишүүд нь дараах ангилалуудын аль нэг нь байна:

1. Бүрэн эрхэт гишүүн: Бүрэн эрхэт гишүүд нь МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн Бүжгийн спортын клуб, сургууль, тэнхим, төвүүд байна.

2. Нэгдсэн гишүүд: Нэгдсэн гишүүд нь МБСХ-ны зорилго, зорилтуудад тустай гэж Ерөнхий чуулганаар хүлээн зөвшөөрөгдөж зарлагдсан байгууллага, холбоод байна.

3. Хувь хүн гишүүд: Хувь хүн гишүүд нь МБСХ-г дэмжигч хувь хүмүүс байна.

4. Хүндэт гишүүд: Хүндэт гишүүд нь Монгол улсын Бүжгийн спортыг хөгжүүлэхэд гарамгай хувь нэмэр оруулсан, Ерөнхий чуулганаар сонгогдсон хувь хүмүүс байна.

### **5-р зүйл. Гишүүнээр элсэн орох, гишүүнчлэлээс хасах**

5.1. Гишүүнээр элсэх өргөдлөө Ерөнхий нарийн бичгийн даргад танилцуулна. Өргөдөл гаргагчийн МБСХ-нд элсэхийг хүссэн өргөдөлд дараах зүйлс багтана:

а. Өргөдөл гаргагчийн дүрэм

б. Өргөдөл гаргагчийн гишүүдийн жагсаалт

в. Өргөдөл гаргагчийн удирдлагын нэр, хаяг, утас, и-мэйл, эрхэлдэг ажил г.м

г. Өргөдөлд: “Бид ОУБСХ, МБСХ-ны ДҮРЭМ, дүрэм журмууд, МБСХ-ны Ерөнхий чуулган, Тэргүүлэгчид, Мэргэжлийн хэлтсийн шийдвэрийг хүлээн зөвшөөрнө” гэсэн үгс байна.

Шаардлагатай бөгөөд тэр нь МБСХ-ны гишүүн байхтай зөрчилдөхгүй бол Тэргүүлэгчид өргөдөл гаргагчаас асуултанд хариулах, санхүүгийн болон бусад мэдээллээр хангахыг шаардаж болно.

5.2. Элсэлтийн асуудлыг Тэргүүлэгчид шийдвэрлэнэ. Өргөдлийг татгалзах тохиолдолд заавал үндэслэл гаргах шаардлагагүй. Хэрэв өргөдлийг татгалзвал өргөдөл гаргагч дараачийн Тэргүүлэгчдийн хуралд танилцуулахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас шаардах эрхтэй.

5.3. Хэрэв өргөдөл гаргагчийн гишүүнээр элсэх өргөдөл Тэргүүлэгчдээр хүлээн зөвшөөрөгдвөл элсэн орсонд тооцно.

5.4. Гишүүнээр элсүүлэх ба гишүүнчлэлийг сэргээхийн тулд жил бүрийн гишүүнчлэлийн татварыг төлөх нь МБСХ бх гишүүдийн хоорондын гэрээ болно. Энэхүү гэрээний хугацаа нь МБСХ-ны гишүүнчлэлийг сэргээх хугацааг багтаана.

5.5 Гишүүд нь МБСХ-ны Дүрэм, дүрэм журмууд, МБСХ-ны Ерөнхий чуулган ба Тэргүүлэгчдийн шийдвэрийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрөх, Дэлхийн Анти-Допингийн дүрэм, МБСХ-ны Анти-допингийн дүрмийг биелүүлэхийг хүлээн зөвшөөрнө.

5.6. Аливаа гишүүнийг МБСХ болон МБСХ-ны Мэргэжлийн хэлтэст шинээр элсэж орох, гишүүнчлэлээ өөрчлөх бүрд бүх гишүүдэд мэдэгдэх ёстой.

5.7. Гишүүд жил бүрийн 3-р сарын 1-ээс өмнө жил бүрийн гишүүнчлэлийн татвараа төлснөөр гишүүнчлэлээ дахин сэргээж болно. Гишүүнчлэлийн татвар нь аливаа өр зээл, нэхэмжлэх хэлбэрээр байж болохгүй.

5.8. Аливаа гишүүн нь хэзээ ч Ерөнхий нарийн бичгийн даргад хаягласан факс, захидлаар МБСХ-ноос огцорч болно. Ингэж огцрох нь тухайн хуанлийн жилийн санхүүгийн үүрэг хариуцлагад нөлөөлөхгүй.

5.9. Аливаа гишүүнийг Тэргүүлэгчдийн хурлын талаас илүү хувийн саналаар хасна. Тухайн гишүүнийг байхгүй бол түүнд гишүүнчлэлээс хассан тухай нэг сарын дотор захидал, факсаар мэдэгдэнэ.

## **6-р зүйл. Маргаан**

Гишүүдийн хооронд болон Гишүүд ба МБСХ-ны хооронд гарч ирсэн маргааныг Ерөнхий чуулган болон Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## **7-р зүйл. Гишүүнчлэлийн татвар**

7.1. Гишүүд нь гишүүнчлэлээ сэргээхийн тулд Санхүүгийн журмын дагуу жил бүрийн татвар төлнө.

7.2. Гишүүнчлэлийн жил бүрийн татварын хэмжээ нь Ерөнхий чуулган дээр олонхийн саналаар засварлагдаж болох бөгөөд засварлагдах шалтгаан нь хэзээ ч гарч болно.

7.3. Гишүүнчлэлийн татварын хугацааг 1-р сарын 1-нээр товлон.

7.4. Гишүүнчлэлийн татварыг 3-р сарын 1-нээс хэтрэлгүйгээр төлсөн байх ёстой.

## **8-р зүйл. МБСХ-ны удирдах албан байгууллагууд**

МБСХ-ны удирдах албан байгууллагууд нь дараах болно:

- а. Ерөнхий чуулган
- б. Тэргүүлэгчид
- в. Тэргүүлэгчдийн Удирдах хороо

## **9-р зүйл. Ерөнхий чуулган**

9.1. Ерөнхий чуулган бол холбооны эрх барих үндсэн байгууллага бөгөөд Гишүүдийн төлөөлөгчид болон Тэргүүлэгчид оролцоно. Гишүүн бүр ерөнхий чуулганд хоёр төлөөлөгчөө оролцуулах эрхтэй.

9.2. Гишүүн бүрийн төлөөлөгчдөөс итгэмжлэгдсэн нэг хүн санал өгнө. Гишүүн бүрээс зөвхөн нэг хүн санал өгч болно.

9.3. Аливаа төлөөлөгч нь гишүүн байгууллагын гишүүн бөгөөд 18 болон түүнээс дээш настай, хувийн болоод бизнесийн хэргийг хууль эрх зүйн хувьд зохион байгуулах боломжтой байх ёстой бөгөөд дараахийн аль нэг байж болохгүй:

а. Аливаа нэгдэл

б. Хаа нэг газар луйвар, санхүүтэй холбоотой гэмт хэргээр яллагдсан г.м

9.4. Зөвхөн МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн загварын хуудсаар өгсөн саналыг хүлээн зөвшөөрнө. Хэрэв саналаа Чуулганд зохих ёсоор гардуулж өгөөгүй, дээрх маягтаар бүрдүүлж гарын үсэг зураагүй, Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрсөн факсын дугаар, хаягаар товлосон хугацаанаас 12 цагийн дотор түүнд өгөөгүй зэрэг шалтгаанаас болж саналыг хүчингүйд тооцно.

9.5. Гишүүд өөр гишүүдийг төлөөлж болохгүй.

9.6. Тэргүүлэгч гишүүд төлөөлөгч болно. Тэргүүлэгч гишүүд санал өгч, хүлээн авч болно.

9.7. Хүндэт гишүүд төлөөлөгч болно. Хүндэт гишүүд санал өгч, хүлээн авч болно.

9.8. Ерөнхий чуулган дээр Гишүүн бүр нэг санал өгнө. Тэргүүлэгч гишүүн бүр нэг санал өгнө. Хүндэт гишүүн бүр нэг санал өгнө. Хувь хүн гишүүд санал өгөхгүй.

9.9. Ерөнхий чуулганыг санхүүгийн жил тутамд явуулах ёстой.

### **10-р зүйл. Ерөнхий чуулганыг зарлан хуралдуулах**

10.1. Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн жилийн 1-р сарын 15-наас өмнө Ерөнхий чуулганыг бүх гишүүдэд захидлаар зарлаж, хуралдуулна.

10.2. Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий чуулганыг эхлэхээс хамгийн багадаа хоёр сарын өмнө чуулганы болох хугацаа, болох газрыг бүх гишүүдэд захидлаар мэдээлнэ.

10.3. Хэлэлцэх асуудлын талаархи саналаа Ерөнхий чуулганаас хамгийн багадаа гурван сарын өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад захидал, факс, и-мэйлээр өргөн барих ба санал гаргах болсон учир шалтгаанаа тайлбарлан хавсаргана.

10.4. Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий чуулганаар хэлэлцэх асуудлын тоймыг чуулганаас хамгийн багадаа хоёр сарын өмнө захидал, факс, и-мэйлээр илгээнэ.

### **11-р зүйл. Ерөнхий чуулганы журам**

11.1. Ерөнхий чуулганыг Ерөнхийлөгч, эсвэл Дэд ерөнхийлөгч, эсвэл Чуулганаар сонгогдсон Төлөөлөгч даргална.

11.2. Хэрэв саналаа өгөх Гишүүд эсвэл саналын талаас илүү нь хүрэлцэн ирсэн тохиолдолд Ерөнхий чуулганыг зохих ёсоор хуралдуулна. Хэрэв Ерөнхий чуулган зохих ёсоор зохион байгуулагдахгүй бол шинэ Ерөнхий чуулганыг 10-р зүйлийн дагуу зохион байгуулж болох ба тэрхүү Ерөнхий чуулган саналаа өгөх Гишүүд эсвэл саналын дөрөвний нэгээс дээш ирсэн тохиолдолд зохион байгуулагдана.

11.3. Шударга ёс болон ардчилсан үйл явц, бизнесийн үр ашигтай удирдлагыг батлах зорилгоор Ерөнхий чуулганы хурлын ажиллагааг дараах дэгээр явуулна.

а. Саналыг аль ч Төлөөлөгч, Тэргүүлэгч гишүүн, Хүндэт гишүүн өгч болно.

б. Чуулганаас өмнө асуудлуудыг дараах дарааллаар эн түрүүнд тавина:

Дэгийн үе шат-Чуулганы дэг журмын талаархи асуулт эсвэл эсэргүүцэл;

Онцгой эрхийн үе шат-Төлөөлөгчид, Гишүүдийн давуу эрхийн талаархи асуулт эсвэл эсэргүүцэл;

Мэдээллийн үе шат-аливаа асуудлын талаархи илүү нэмэлт мэдээлэл, тайлбар

в. Тэргүүлэгч гишүүн бүр Ерөнхий чуулган дээр үг хэлж болох бөгөөд хэлэлцүүлгийн үеэр i. Дарга, ii. Тэргүүлэгч гишүүд, iii. Төлөөлөгчид, iv. Хүндэт гишүүд, v. Зочид гэсэн дарааллаар саналаа гаргана:

г. Дарга Төлөөлөгчдийн үг хэлэх хүсэлтийг дээрх дарааллаар хүлээн зөвшөөрнө.

д. Дарга хэлэлцүүлэг болон санал гаргагчдийн үг хэлэх хугацааны хязгаарыг тогтоож болох ба аливаа асуудлаар үг хэлэхийг хүсэгчдэд ижил тэнцүү хугацаа хуваарилж болно.

е. Саналыг зөвхөн энэхүү ДҮРЭМ-д заагдсан “Хэн энэ саналын талд байна” гэсэн санал хураалтаар оруулж, залруулж, татан авч, эмхэлж болно.

ё. Дэгийн үе шатан дахь маргаан хэлэлцүүлгийг Чуулганы олонхийн саналаар хаана.

ж. Дэгийн талаар санал зөрөх тохиолдолд Даргын шийдвэрээр эцэслэн шийдвэрлэнэ.

11.4. Ерөнхий чуулган нь тогтоол, шийдвэрээ Төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэхүү ДҮРЭМ-ийг гуравны хоёрын олонхийн саналаар засаж залруулна. Аливаа саналд түдгэлзсэн болон хүчингүй саналыг тооцохгүй. Хэрэв санал тэнцвэл Ерөнхийлөгч эсвэл түүний эзгүйд Дарга шийдвэрлэх саналыг хэрэгсэхгүй болгох эсвэл тэрхүү санал хүчингүй болно.

11.5. Саналыг гар өргүүлж авна, эсвэл Төлөөлөгчдийн гуравны нэг нь шаардвал нууцаар авна.

11.6. Ерөнхий чуулганаас энэхүү ДҮРЭМ-ийн 13-р зүйлд заасны дагуу Тэргүүлэгч гишүүдийг, 18-р зүйлд заасны дагуу Санхүүгийн хяналтын зөвлөлийг сонгоно.

11.7. Ерөнхий чуулган бүрийн протоколыг бичгээр гаргаж, түр завсарласны дараа хоёр Тэргүүлэгч гишүүн нэн даруй хянаж шалгана. Түүнийг хагас сарын дотор Ерөнхийлөгч болон өөр нэг Тэргүүлэгч гишүүн хянаж гарын үсгээ зурна. Хуулбарыг Чуулган дууссанаас хойш нэг сарын дотор бүх Гишүүдэд захидал, факс эсвэл и-мэйлээр илгээнэ.

11.8. Энэхүү ДҮРЭМ-ийн эсрэг зүйл гарч болох боловч Тэргүүлэгчид урьдчилан анхааруулахгүйгээр гуравны хоёрын олонхийн саналаар батлахыг шаардсан саналыг Ерөнхий чуулганд өргөн барьж болно.

11.9. Онц Ерөнхий чуулганыг Тэргүүлэгчдийн шийдвэрээр хуралдуулж болно. Эсвэл санал өгөх эрх олгогдсон Гишүүдийн хамгийн багадаа гуравны хоёрын саналаар хуралдуулна.

11.10. Онц Ерөнхий чуулганыг 10-р зүйлийн дагуу даруй хуралдуулна.

11.11. Онц Ерөнхий чуулган нь Ерөнхий чуулган мөн бөгөөд ердийн Ерөнхий чуулганы адил хэрэгцээ шаардлагатай байна.

## **12-р зүйл. Шуудангаар санал авах**

Ерөнхий чуулганы журамд нэмэлт болгож Тэргүүлэгчид ДҮРЭМ-д засвар оруулахаас бусад тохиолдолд саналыг шуудан эсвэл факсаар авч болно. Гишүүд хамгийн багадаа нэг сарын өмнө санал өгөхөөр хүлээн зөвшөөрөгдсөн байна. Санал тэнцсэн, түдгэлзсэн тохиолдолд саналыг хүчингүйд тооцно. Энэхүү журмыг “Шуудангаар санал авах” гэнэ. Шуудангаар ирсэн санал нь Тэргүүлэгчид санал авч

дуусах хугацаа хүртэл Гишүүдийн тавин хувь нь саналаа өгсөн тохиолдолд хүчинтэй болно.

### **13-р зүйл. Тэргүүлэгчид**

13.1. Тэргүүлэгчид нь МБСХ-ны хоёрдогч эрх барих байгууллага бөгөөд Ерөнхий чуулган хүртэл холбоог удирдана.

13.2. Ерөнхий чуулганаас Тэргүүлэгчдэд дараачийн Ерөнхий чуулган хүртэл МБСХ-ны үйл ажиллагааг удирдах, Монгол улсын Бүжгийн спортын төлөө МБСХ-г төлөөлөх эрх олгогддог.

13.3. Тэргүүлэгчид нь дараах хүмүүсээс бүрдэнэ. Үүнд:

- Ерөнхийлөгч
- Дэд ерөнхийлөгч
- Ерөнхий нарийн бичгийн дарга
- Санхүүч
- Спорт эрхэлсэн захирал
- 6 хүртэл ердийн гишүүд
- Хүндэт ерөнхийлөгч

Ердийн гишүүд нь Ерөнхийлөгч болон Тэргүүлэгчдийн удирдлаган дор олон талын ажил үүргийн үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ.

13.4. Тэргүүлэгчид болон Хүндэт Ерөнхийлөгч, Мэргэжлийн хэлтсийн захирлыг дөрвөн жил тутамд Ерөнхий чуулган дээр нууц санал хураалтаар сонгоно.

13.5. Тэргүүлэгчдэд нэр дэвшигч нь өндөр санал авч байж сонгогдоно. Хэрэв хоёр эсвэл түүнээс олон нэр дэвшигчид хайнцвал дахин сонгууль явуулна. Олонхийн саналыг авсан нэр дэвшигч сонгогдоно.

13.6. Хэн хэн нь хувийн болоод бизнесийн хэргийг хууль эрх зүйн хувьд зохион байгуулах боломжтой байх ёстой. Дараах байж болохгүй:

а. Аливаа нэгдэл;

б. Хаа нэг газар луйвар, санхүүтэй холбоотой гэмт хэргээр яллагдсан г.м;

Тэргүүлэгчид болон Удирдах хороонд Төлөөлөгч эсвэл Тэргүүлэгч гишүүн биш хүн сонгогдож болно. Хэрвээ Тэргүүлэгчдэд сонгогдохоор урьдчилан зөвшөөрөгдөөгүй бол Ерөнхий чуулганд хүрэлцэн ирээгүй хүнийг Тэргүүлэгчдэд сонгож болохгүй.

13.7. Хэрэв хэн нэг Тэргүүлэгч гишүүний ажлын байр эзэнгүй болбол Тэргүүлэгчид нэг сарын дотор түүний сул орон тоон дээр дараагийн сонгууль явагдах Ерөнхий чуулган хүртэл хугацаагаар ажиллах залгамжлагчийг томилж болно.

13.8. Тэргүүлэгчид Комиссуудын гишүүдийг томилж бүрдүүлнэ. Комиссууд нь Тэргүүлэгчдийн ажилд туслах бөгөөд Спорт техникийн комисс, Санхүүгийн комисс, Хэвлэл мэдээллийн комисс, Боловсролын комисс, Сахилгын комисс, Гишүүнчлэлийн комисс, Арбитрын комисс байна. Тэд ажлаа Тэргүүлэгчдэд тайлагнах үүрэгтэй.

13.9. Тэргүүлэгчид Бүжгийн спортыг хөгжүүлэхэд туслах зорилгоор Гүйцэтгэх албаны 15 хүртэл гишүүдийг томилох, ажлаас халах эрхтэй.

13.10. Тэргүүлэгч гишүүн бүр МБСХ-ны өмнө шударга, өндөр чадвартай байх үүрэгтэй.

#### **14-р зүйл. Тэргүүлэгчдийн эрх мэдэл**

14.1. Ерөнхий чуулган хуралдаагүй үед Тэргүүлэгчид нь энэхүү ДҮРЭМ-д заагдсаны дагуу Ерөнхий чуулган хүртэл бүрэн эрх мэдэлтэй байх бөгөөд МБСХ-ны дүрэм журмуудыг зөрчиж гуйвуулсан, МБСХ-нд хор хөнөөл учруулсан Гишүүд, тамирчид, Тэргүүлэгчид бусад хүмүүсийн эсрэг арга хэмжээ авах бүрэн эрхтэй. Ийм тохиолдолд Тэргүүлэгчид нь өөрийн эрх мэдлийн хүрээнд арга хэмжээ авах бөгөөд энэ нь дараах зүйлсээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Аливаа тэмцээн зохион байгуулах, Гишүүдийн тамирчдыг аливаа тэмцээнд оролцохыг хориглох;

- Гишүүдийг сануулж, донгодох;
- Гишүүний онцгой эрхийг бүхлээр нь эсвэл зарим хэсгийг цуцлах;
- Гишүүний гишүүнчлэлийг хүчингүй болгох;
- Хувь хүмүүсийг албадах, хүчлэх зэрэг тохирсон хориг арга хэмжээ авах.

14.2. Тэргүүлэгчдийн ийм шийдвэрийн эсрэг хүсэлтийг дараачийн Ерөнхий чуулган дээр гаргаж болох бөгөөд маргааныг 6-р зүйлийн дагуу шийдвэрлэнэ.

14.3. Тэргүүлэгчид МБСХ-ны үйл ажиллагааг илүү ардчилсан, хамтач, үр дүнтэй удирдан явуулах зорилгоор өөрийн Хуулийн зөвлөхийг сонгож болно.

#### **15-р зүйл. Тэргүүлэгчдийн ажил**

15.1. Тэргүүлэгчид нь ажлаа захидал, факс, и-мэйлээр явуулна. Тэргүүлэгчдийн хурал нь гишүүдийн талаас илүү нь ирсэн тохиолдолд хуралдана. Хуралд ирэх замын зардлыг МБСХ-ны сангаас боломжийн хэрээр гаргана.

15.2. Тэргүүлэгчдийн шийдвэр олонхийн саналаар шийдэгдэнэ. Ерөнхийлөгч нь Тэргүүлэгчдийн аливаа хайнцсан саналыг хэрэгсэхгүй болгох саналаа өгч болно. Аливаа саналын үр дүнг бүх Гишүүдэд хойшлуулахгүйгээр мэдэгдэнэ.

#### **16-р зүйл. Удирдлага ба Төлөөлөл**

16.1. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Санхүүч, Спорт эрхэлсэн захирал нь Удирдах хороог бүрдүүлэх бөгөөд Тэргүүлэгчдээс тусдаа байж МБСХ-г төлөөлнө.

16.2. Удирдах хороо нь МБСХ-ны үйл ажиллагааг Орчин үеийн спортын зарчим ба Менежментийн зарчмуудад нийцүүлэн удирдан явуулах үүрэг, эрх мэдэлтэй.

16.3. Ерөнхийлөгч нь МБСХ-ны гол бодлогыг төлөөлөгч бөгөөд МБСХ-ны доторхи тохиролцоог бий болгох, удирдах үүрэг, эрх мэдэлтэй. Ерөнхийлөгч нь мөн МБСХ-ны Гүйцэтгэх албаны дарга бөгөөд МБСХ-ны бизнесийн болоод спортын өдөр тутмын хэргийг удирдан явуулах бүрэн эрхтэй.

16.4. Дэд ерөнхийлөгч нь МБСХ-ны гол бодлогыг орлон төлөөлөгч бөгөөд Ерөнхийлөгчийн удирдлаган дор МБСХ-ны доторхи тохиролцоог бий болгох, удирдан явуулах үүрэг, эрх мэдэлтэй. Дэд ерөнхийлөгч нь мөн МБСХ-ны Гүйцэтгэх албаны туслагч бөгөөд Ерөнхийлөгчийн удирдлаган дор МБСХ-ны өдөр тутмын бизнесийн болоод спортын хэргийг удирдах бүрэн эрхтэй. Ерөнхийлөгчийн хугацаа дуусах, огцрох, ажлын чадвараа алдах үед Дэд ерөнхийлөгч нь дараагийн Ерөнхийлөгчийг сонгогдтол Ерөнхийлөгчийн албан тушаал, эрх мэдэл, оффисын эрх мэдлийг бүрнээр нь авах үүрэг, эрх мэдэлтэй.

16.5. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МБСХ-ны оффисын хэрэг болоод Вэб хуудсыг эрхлэх бөгөөд Ерөнхийлөгчийн удирдамж зааврыг дагаж ажиллана.

16.6. Санхүүч нь МБСХ-ны Санхүүгийн албаны дарга бөгөөд МБСХ-ны санхүү, тайлан бүртгэлийн өдөр тутмын хэргийг Орчин үеийн менежментийн зарчмуудад нийцүүлэн удирдан явуулах үүрэг, бүрэн эрхтэй. Санхүүч нь Ерөнхий чуулган болон Тэргүүлэгчдэд МБСХ-ны санхүү, тайлан бүртгэлийн хэргийн талаар илтгэж байх үүрэгтэй.

16.7. Спорт эрхэлсэн захирал нь МБСХ-ны Спортын албаны дарга бөгөөд МБСХ-ны спортын өдөр тутмын хэргийг Орчин үеийн спортын болоод менежментийн зарчмуудад нийцүүлэн удирдан явуулах үүрэг, бүрэн эрхтэй. Спорт эрхэлсэн захирал нь Ерөнхий чуулган болон Тэргүүлэгчдэд МБСХ-ны спортын хэргийн талаар илтгэж байх үүрэгтэй.

### **17-р зүйл. Мэргэжлийн хэлтэс**

17.1. Мэргэжлийн хэлтэс нь **МБСХ-ны Мэргэжлийн хэлтсийг** үндэслэн, удирдаж, МБСХ-ны дотор мэргэжлийн Бүжгийн спортын тэмцээний дүрэм ба мэргэжлийн тамирчид, багш нар, дасгалжуулагчид, шүүгчдийг багтаасан мэргэжлийн Бүжгийн спортын тэмцээнийг бий болгох үүрэг хүлээнэ.

17.2. Мэргэжлийн хэлтэс нь дээр зааснаар мэргэжлийн Бүжгийн спортыг удирдаж, өөрийн салбар, комиссуудыг үндэслэж болох боловч МБСХ-ны дотоод гадаад удирдлагын эрх зүй, орчин үеийн чөлөөт нийгмийн ардчилсан зарчим, орчин үеийн спортын зарчмууд, орчин үеийн удирдлагын зарчмууд, бүхий л холбогдох хууль тогтоомжийг үргэлж хүндэтгэн үзнэ.

17.3. Мэргэжлийн хэлтсийг Мэргэжлийн хэлтсийн захирал ба МБСХ-ны мэргэжлийн гишүүдээс эсвэл ижил төстэй мэргэжлийн хэсгээс сонгосон хоёр төлөөлөгчөөс бүрдүүлэн зохион байгуулна. Мэргэжлийн хэлтсийн хурал, зөвлөгөөн дээр Мэргэжлийн хэлтсийн захирал нэг, гишүүн бүр нэг санал өгнө. Мэргэжлийн хэлтсийн захирал ба төлөөлөгчид ажлаа Мэргэжлийн хэлтсийн хурал дээр эсвэл и-мэйл, утас, факс зэргээр явуулна.

17.4. Мэргэжлийн хэлтэс нь МБСХ-ны Мэргэжлийн хэлтсийн захирлыг хамгийн багадаа дөрвөн жилээр томилох буюу дахин томилж болох ба хэдэн ч удаа сонгож болно. МБСХ-ны Мэргэжлийн хэлтсийн захирал нь Мэргэжлийн хэлтсийн удирдах төлөөлөгч, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн удирдах ажилтан байна.

17.5. Мэргэжлийн хэлтэс нь хэрвээ өөрсдөө хүсвэл өөрийн санхүүтэй, тусдаа хөрөнгөтэй, аливаа мөнгийг хүлээн авах зарцуулах тусдаа банкны данстай байж, хөрөнгөө захиран зарцуулж болно. Гэхдээ Мэргэжлийн хэлтсийн захирал энэ тухайгаа МБСХ-ны санхүүчид зургаан сар тутамд тайлагнаж байх ёстой.

17.6. Мэргэжлийн хэлтсийн захирал Мэргэжлийн хэлтсийн санхүүгийн тайлангаа Ерөнхий чуулган бүр дээр танилцуулах ёстой.

### **18-р зүйл. Санхүү**

18.1. Санхүүч нь МБСХ-ны тайлан, данс, тооцоо, бүртгэлийг санхүүгийн нарийн горимоор удирдан явуулна.

18.2. Санхүүч нь санхүүгийн тайлангаа Ерөнхий чуулган болон Тэргүүлэгчдийн хурал бүр дээр танилцуулах ёстой.

18.3. Ерөнхий чуулган дээр Санхүүгийн хяналтын байцаагчийг томилно. Санхүүч жил бүрийн Ерөнхий чуулганы өмнө Санхүүгийн хяналтын байцаагчийн гарын



үсэгтэй тайланг авч, Ерөнхий чуулган эхлэхээс өмнө Төлөөлөгчдөд хуви­лан тараана.

### **19-р зүйл. Хүндэтгэл**

19.1. Хүндэт ерөнхийлөгч болон Хүндэт гишүүдийг Ерөнхий чуулганаар сонгоно. Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу тэд зөвлөж, ёслолын үйл ажиллагаанд оролцоно.

19.2. Ерөнхий чуулган болон Тэргүүлэгчдээс Монголын Бүжгийн спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь зүй ёсоор үнэлж Хүндэт цол олгож болно.

### **20-р зүйл. Дүрэм, журмууд**

20.1. МБСХ-нд дараах дүрэм, журмууд үйлчилнэ:

а. Санхүүгийн журам;

б. Тэмцээний дүрэм;

в. Мэргэжлийн хэлтсийн дүрэм;

г. Шүүгчдийн коллегийн журам; Шүүгчдийн зан байдлын ёс зүйн хэм хэмжээний дүрэм

д. Тамирчны ур чадварын зэрэглэл ба насны ангилалын дүрэм;

е. Зөвшөөрөгдсөн бүжиг ба хөдөлгөөнүүдийн тухай дүрэм;

ё. Спортын хувцасны журам;

ж. Анти-Допингийн дүрэм

з. Сахилгын комиссын журам

20.2. Анти-Допингийн дүрэм бол ДҮРЭМ-ийн бүрэлдэхүүн хэсэг юм.

20.3. **Мэргэжлийн хэлтсийн дүрмийг** зөвхөн Мэргэжлийн хэлтсийн төлөөлөгчдийн дийлэнх тохиролцсоноор Ерөнхий чуулган дээр болон шуудангаар санал хураан засвар оруулж болно.

20.4. Бусад дүрэм, журмууд нь ДҮРЭМ-ийн бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд Ерөнхий чуулган дээр болон шуудангаар санал хураан засвар оруулж болно.

20.5. Тамирчид, багш дасгалжуулагчид, шүүгчид нь МБСХ-ны Дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

### **21-р зүйл. МБСХ-г татан буулгах, дампууруулах**

21.1. МБСХ-г тараах асуудлыг зөвхөн Гишүүдийн хамгийн багадаа гуравны хоёр нь оролцсон Ерөнхий чуулган дээр гуравны хоёроос багагүй санал, шаардлагаар шийдвэрлэнэ.

21.2. МБСХ-г тараах эсвэл хүчингүй болговол түүний хөрөнгийг Монголын Үндэсний Олимпийн Хороо эсвэл Монгол улс ба Олимпийн хороогоор хүлээн зөвшөөрөгдсөн ижил төстэй спортын холбоо, холбоодод шилжүүлнэ. МБСХ-ны Гишүүдэд төлбөр төлөхгүй.

### **22-р зүйл. МБСХ-ны нийтийн хэл**

22.1. МБСХ-ны албан ёсны хэл бол Монгол хэл юм.

22.2. Гадаад хэргийг ОУБСХ-ны албан ёсны хэл Англи хэлээр хөтлөн явуулна.